



ЭКО АСФАЛТ

“ЭКО АСФАЛТ” ХХК

ЗАМ БАРИЛГА, БЕТОН ЭДГЭЛ, АСФАЛТБЕТОН
ХОЛЫЦЫН ҮЙЛДВЭР

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,

3-р хороо, ГЭЦ-3 баруун талд

Утас: 99115898, 94115020

И-мэйл: eco.asphalt99@gmail.com

2023.10.30 № 2335

танай _____-ны № _____-т

Хүсэлт гаргах нь

Манай “Эко асфальт” ХХК нь авто замын материал үйлдвэрлэлийн чиглэлээр Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд асфальтбетон хольцын үйлдвэрийн төслийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө биелэлтийн тайланг хүлээн авна уу.

ЗАХИРАЛ



Д.БАТБОЛД



“ЭКО АСФАЛЬТ” ХХК

**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ
НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “АСФАЛЬТ БЕТОН ХОЛЬЦЫН
ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2023

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН
"ЭКО АСФАЛЬТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Г.БАТБОЛД

УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ "АСФАЛЬТ БЕТОН ХОЛЬЦЫН ҮЙЛДВЭР" ТӨСЛИЙН 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

Регистрийн дугаар: 600176

ХҮЛЭЭН АВЧ, ХЯНАСАН:
НБОГазрын мэргэжилтэн

Ж. БАТЗОЛБОО

БЕЛЭЛТИЙН ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН
МАТЕРИАЛЫН ИНЖЕНЕР

О. Алтан-Өлзий

О. АЛТАН-ӨЛЗИЙ

2023

Агуулга

ОРШИЛ.....	2
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.....	2
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
1.2 Төслийн хүчин чадал	5
1.3 Төслийн дэд бүтцийн байдал	6
1.4 Төслийн тоног төхөөрөмж, технологи	8
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл	11
Төслийн гол сөрөг нөлөөлөл.....	13
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН	14
3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	15
3.2 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	
3.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	16
3.4 Болзошгүй аюул, ослын менежментийн төлөвлөгөөний биелэлт	16
3.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	16
3.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	18
3.7 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	25
3.8 2022 оны БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах мэдээ	25
ДҮГНЭЛТ.....	26

ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй “Асфальт бетон хольцын үйлдвэр” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалын “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-г үндэслэн хийдэг.

Төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад зорилго оршино.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан төлөвлөгөөг ойлгоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газар, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн бол сумын Засаг даргад хүргүүлэн хянуулж батлуулна.

Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага болон сумын Засаг дарга хянаж, баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн бичиг баримт болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОННУ-ний тайланг үнэлгээний мэргэжлийн зөвлөл хэлэлцэн баталснаас хойш төсөл хэрэгжүүлэгч 1 сарын дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад батлуулахаар хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, төслийн танилцуулга, төслийн хэрэгжилтийн явц, ашиглаж байгаа техник технологи, төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга хэсгүүд баримтлах хууль тогтоомж, стандартын шаардлага болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг тодорхой тусгана.

Төсөл хэрэгжүүлэгчийн хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагаа нь зах зээл, эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт үзэгдэл, тухайн бүс нутаг, хүн амыг хамарсан халдварт өвчин, тахал зэрэг давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас зогсонги байдалд орсон бол энэ талаараа ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 1 сарын дотор хандан, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй болсон талаараа мэдэгдэж, дээрх шалтгаан арилах хүртэл түр хойшлуулах хүсэлт гарган шийдвэрлүүлнэ.

Тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй талаарх тодорхойлолтыг төсөл хэрэгжиж буй сум, дүүргийн Засаг дарга хэд хэдэн сум, дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн хувьд аймаг, нийслэлийн байгаль орчны газар тодорхойлсон байна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү журамд заасан шаардлагыг хангаж боловсруулаагүй бол түүнийг хүлээн авч хянах, батлахаас татгалзах үндэслэл болно.

Ашигт малтмал ашиглах, хайх, дэд бүтцийн барилга байгууламж барих зэрэг улирлын шинж чанартай үйл ажиллагаа явуулдаг төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны

менежментийн төлөвлөгөөг тэдгээрийн тухайн оны төлөвлөлттэй уялдуулан эхний улиралд багтаан хянаж, эцэслэн батална.

Байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч 2 жил тутамд байгаль орчны хуваарьт аудит хийлгэн, аудитын тайлан болон аудитын зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг аймаг, нийслэлийн байгаль орчны газарт ирүүлж, уг аудитын тайлан, зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланд менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн талаар бодит мэдээлэл, дүгнэлтийг тусгасан байх бөгөөд хугацааны хувьд давхцаж байвал тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага дүгнэх нөхцөл болгож болно.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

- Төслийн нэр :** “Асфальтбетон хольцын үйлдвэр” төсөл
- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр :** “Хувийн хөрөнгө оруулалттай “ЭКО АСФАЛТ” ХХК
Улсын бүртгэлийн дугаар: 9011571011 Регистрийн
дугаар: 6001769 Аж ахуйн нэгж байгууллагын газар
эзэмших эрхийн гэрчилгээний дугаар:0232523 -10000м² “
Би Ти ӨҮ” ХХК-ийн газрыг түрээслэн үйл ажиллагаагаа
явуулж байна.
- Хаяг:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3-р хороо ТЭЦ-3-ын
баруун урд талд байрладаг. Утас: 94115021,94115020
- Төслийн байршил:** Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт 3-р хороонд байрлах
ба Яармагийн гүүрнээс баруун хойно 400 метрт өөрөөр
хэлбэл 3-р ДЦС -ын баруун урд талд 350 метр зайд туслах
замын хажууд 10000 м² талбайд байрлана.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжих газрын захын цэгүүд

Цэгийн дугаар	Геодезийн солбицол		Талбайн хэмжээ (га)
	X	Y	
1	47° 53' 28.36"	106° 51' 29.39"	1.0
2	47° 53' 28.88"	106° 51' 28.86"	
3	47° 53' 30.20"	106° 51' 27.49"	
4	47° 53' 32.12"	106° 51' 31.42"	
5	47° 53' 28.66"	106° 51' 34.94"	



Зураг 1.Төсөл хэрэгжих талбайн байршлын зураг

1.2 Төслийн хүчин чадал

Асфальтбетон зуурмагын үйлдвэрийн хүчин чадал:

Тус асфальтбетон хольцын үйлдвэр нь БНХАУ-ын LONGLI MECHANICAL ХХК-д үйлдвэрлэсэн LB-1200 маркийн бүрэн автомат тоног төхөөрөмжтэй бөгөөд энэ цагт 120 тн асфальт гаргах хүчин чадалтай юм.

Асфальтбетон нь битум болон жижиг том дүүргэгч эрдэс нунтагийг тогтсон харьцаагаар хийж нэг төрлийн болтол хольж зуурсаны дараа тэр нь бэхжих процесс эхлэх хүртэл өөрийн хөдөлгөөнт чанараа хадгалж байгаа асфальт бетон хольц юм.

Асфальтбетон хольцын түүхий эд болох битумыг дотоодын зах зээлээс худалдан авдаг ба шингэн битумыг хадгалах тус бүрдээ 50 тн даацтай 9 ширхэг савыг үйлдвэрийн дэргэд газар доор суурилуулсан. Мөн хайрга, элсийг дотоодын зах зээлээс худалдаж авч ашигладаг. Асфальтбетон хольцод ашиглах дүүргэгч дайрга нь MNS 0390:1998, элс нь MNS 0392:2014, барьцалдуулагч битум нь MNS 6237:2010, MNS 5230:2002, эрдэс нунтаг нь MNS 4904-1:2000 стандарт техникийн нөхцөл шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 2. Асфальтбетоны орц ба үйлдвэрт бэлтгэж зуурч гаргаж байгаа хольцын ерөнхий техникийн үзүүлэлт

Д/Д	Материал	Хувиар /%/	Нэг зууралтанд 1000 кг	Нийлүүлэгч компани
1	Дайрга /10-20мм/	10,0	100	“Цээцээ Импекс” ХХК
2	Дайрга /5-10мм/	35,0	350	“Цээцээ Импекс” ХХК
3	Элс /0-5/	48,0	480	“Цээцээ Импекс” ХХК
4	Эрдэс нунтаг	7,0	70	“Тэвхэн” ХХК
5	Битум БНД100/130	5,5	55	“Монголбитум индустрал” ХХК

Асфальтбетон хольц бүрдүүлэгч материалууд нь түүний чанарт янз бүрээр нөлөөлдөг тухайлбал: дайрга, /хайрга/ нь хучилтын бат бэх, хөшүүн байдлыг хангаад зогсохгүй авто замаар өнгөрөх тээврийн хэрэгслэлүүдийн үйлчилгээн доорх эсэргүүцлийг сайжруулах гол араг яс, их бие нь болдог бол элс нь хольцын томоохон нүх сүв зайнуудыг дүүргэж хольцыг илүү уян хатан болгодог байна. Асфальтбетон хольцын бат бэх нь түүнд эрдэс нунтаг оруулсанаар хангагдана.

Эрдэс нунтаг нь битумтэй хамт наалдамтгай материал болж хольцын эрдсийн хэсгүүдийн хоорондох барьцалдалгааг хангаж хүчитгэн улмаар хучилтын цул байдлыг бий болгож түүний механик бат бэх, дулаанд тогтвортой чанарыг дээшлүүлнэ.

Битумын хувьд түүний гол шинж чанар нь зууралдмал, уян хатан наалдуулах чанарт орших бөгөөд энэ материал нь ус болон халуун хүйтний үйлчилгээний эсрэг тогтвортой, тодорхой хэсэг хугацааны дотор уян хатан байдлаа хадгалаж чаддаг чанартай юм.

Иймээс битумын наалдуулах чадварыг нэмэгдүүлэхийн тулд мөн чулуун материалын гадаргууг зөвхөн бүрээд зогсохгүй түүнд улам сайн шингээх зорилгоор аль аль материалуудыг тогтоосон хэмжээнд нь хүртэл заавал халаах ёстой байдаг.

Халаах процессыг 3-р “ДЦС” - тай хийсэн “Уурын Дулаан Эрчим Хүч Худалдах Худалдан Авах” гэрээний дагуу стандарт шаардлагыг хангасан халуун уураар хангана.

Дулааны горим ёсоор хайрга, /дайрга/ элсэн материалыг 180° хүртэл, битумыг төрөл маркаас нь хамааруулан өтгөн битумыг 140-170°, шингэн битумыг 70-100° хүртэл тус тус халаана. Хэт

хүйтэн эрдэс нунтаг хэрэглэх тохилдолд хайрга / дайрга/ , элсийг халаах температурыг 200-220⁰ –д хүргэдэг.

Хүснэгт 3. Асфальтбетонд орох битумын марк, үйлдвэрээс гарах, замд дэвсэх үеийн хольцын температур

Хольцын төрөл	Битумын марк	Хольцын доошгүй байх температур	
		Холигчоос гарах үед	Замд дэвсэх үед
Халуун	Бнд 40/60 Бнд 60/90 Бнд 90/130 Бнд 100/130	140-160	120

Хэрэв идэвхжүүлсэн эрдэс нунтаг хэрэглэсэн тохиолдолд халуун хольцны энэ температурыг 20⁰ С-аар багасгаж харин дэвсэх үеийн температур нь 5-аас бага байвал хүснэгтийн температурыг 10⁰ С-аар нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

Өтгөн битумын хувьд манай нөхцөлд Бнд 60/90, Бнд 90/130, Бнд 100/130марк нь илүү тохиромжтой байдаг байна.

Асфальтбетоны үндсэн түүхий эд болох Бнд90/130”маркын битумыг “Монголбитум индустрал” ХХК-иас баталгаажсан шинжилгээний бичигтэйгээр нийлүүлдэг. Мөн эрдэс нунтагийг “Тэвхэн” ХХК -иас баталгаажсан шинжилгээний бичигтэй нийлүүлдэг.

1.3 Төслийн дэд бүтцийн байдал

Цахилгаан хангамж: Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах “ЭКО АСФАЛЬТ” ХХК-ийн Асфальтбетон хольцын үйлдвэрийн бүс нь цахилгаан эрчим хүчний төвлөрсөн сүлжээнд холбогдсон ба үйлдвэрийн хашаандаа өндөр хүчдэлийн үүсгүүртэй.



Зураг 2.Өндөр хүчдэлийн үүсгүүр

Усан хангамж: Үйлдвэрийн усаа төвийн шугамнаас татан авч хэрэглэдэг. Унд ахуйн усаа зөөврөөр ажигладаг.

Харилцаа холбоо: Уг үйлдвэр нь дэд бүтцийн хөгжил сайтай газар байрладаг тул харилцаа холбоо чөлөөтэй.

Хог хаягдал: “

Шингэн хог хаягдал – Үйлдвэрийн хувьд шингэн хог хаягдал нь асфальт үйлдвэрлэх процессын үед гарах хийн хаягдалыг усан хөшигнөөс буух шингэн хаягдлаа газрын гадаргаас доош ухсан 2м гүн 10х6 метр хатуу гадаргуутай бункерт хуримтлуулан дүүрмэгц ӨГӨЖИХ ХАУС ХХК – тэй байгуулсан гэрээний дагуу соруулан авдаг.



Зураг 3. Шингэн хаягдал цуглуулах пункер

Хатуу хог хаягдал – Үйлдвэрийн процесс нь дайргаа $+165^{\circ}$ хүртэл халаах хэрэгтэй байдаг ба үйлдвэрийн зарим процессд доголдол гарснаар хүрэх ёстой температурт хүрээгүй дайрга нь үйлдвэрийн хатуу хог хаягдалд тооцогдоно. Гэхдээ үйлдвэрийн хашаанд хатуу хог хаягдал болох дайргыг хатуу хучилт болгон дахин ашиглаж байгаа.

Мөн ажилчдын унд ахуйн хэрэглээнээс ахуйн хог хаягдал багагүй ялгарах ба эдгээр хог хаягдалыг үйлдвэрийн байрлах дүүргийн ТҮК– тэй гэрээ байгуулан ачиж тээвэрлэнэ.

Уг үйлдвэр нь 13 ажилчинтай: нэг хүн 0,3 кг хог хаягдал гаргана гэж үзвэл $13 \cdot 0,3 \text{ кг} = 3,9 \text{ кг}$ хаягдал өдөрт гарах ба сард $30 \cdot 3,9 = 117 \text{ кг}$ ахуйн хог хаягдал гарахаар тооцлоо.

1.4 Төслийн тоног төхөөрөмж, технологи



Зураг 4. “Битум БНД100/130”



Эрдэс нунтаг

Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн жагсаалт

Д/Д	Тоног нэр	төхөөрөмжийн	Х/Н	Тоо ширхэг	Үйлдвэрлэсэн улс	Ашиглаж буй хугацаа / жил /	Ажиллагаа
АСФАЛЬТБЕТОН Үйлдвэр							
1	LBR 1500 JRM АБЗ		ш	1	Хятад	3	Хэвийн
2	LB 1500 АБЗ		ш	1	Хятад	2	Хэвийн
3	ДС 117-2К АБЗ			2	Орос	22	Хэвийн
4	KIEEMANN хөдөлгөөнт бутлуур		ком	1	Герман	3	Хэвийн
ЛАБОРАТОРИ /Асфальтбетон/							
1	Электронжин		ш	3	Итали	5	Хэвийн
2	Хатаах зуух		ш	1	Энэтхэг	3	Хэвийн
3	Мечта плитка		ш	2	Орос	3	Хэвийн
4	Маршалл пресс		ш	2	Солонгос	2	Хэвийн
5	Домакарат		ш	2	Орос	2	Хэвийн
6	Асфальтоны /автомат/ алх		ш	2	Энэтхэг	10	Хэвийн
7	Битумын суналт үзэгч		ш	4	Хятад	2	Хэвийн
8	Асфальтбетоны холигчийн тогоо		ш	1	Англи	5	Хэвийн
9	Хувийн жингийн сагс		ш	2	Хятад	3	Хэвийн
10	Асфальтбетоны металл хэв		ш	25	Орос	5	Хэвийн
11	Суурь		ш	25	Орос	5	Хэвийн
12	Усан банн		ш	4	Хятад	3	Хэвийн
13	Корын машин		ш	2	Хятад	3	Хэвийн
14	Шигшүүр		ком	16	Англи	3	Хэвийн
15	Зуухны термометр		ш	1	Хятад	3	Хэвийн
16	Лабораторийн тавиур		ш	3	Орос	10	Хэвийн
17	Асфальтбетоны халбага		ш	3	Хятад	1	Хэвийн
18	Хэмжээт сав		ш	3	Хятад	1	Хэвийн

**Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК
-ийн “Асфальтбетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

19	Битумын дөл авалцах градусыг тодорхойлох багаж	ш	1	Хятад	3	Хэвийн
20	Битумын суналтыг тодорхойлох аппарат	ш	1	Хятад	3	Хэвийн
21	Галын унтраагуур	ш	2	Монгол	1	Хэвийн
22	Галын заавар самбар	ш	1	Монгол	1	Хэвийн
23	Хориглох тэмдэг	ш	1	Монгол	1	Хэвийн
24	Түмпэн жижиг	ш	6	Хятад	3	Хэвийн
25	Түмпэн дунд	ш	6	Хятад	3	Хэвийн
26	Түмпэн том	ш	6	Хятад	3	Хэвийн
27	троссон шотек	ш	2	Хятад	2	Хэвийн

Хятад улсад үйлдвэрлэгдсэн LB 120 маркийн цагт 110 - 120 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бүрэн автомат Асфальтбетон үйлдвэрлэгч бөгөөд байгаль орчинд хор нөлөөгүй, усан филтертэй, эко тоног төхөөрөмж юм.



Зураг 5. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Төслийн технологи шат дамжлага

Үйлдвэрийн технологийн дараалал

1. Үйлдвэр бүхэлдээ тогоор ажилладаг. 4 төрлийн бункертэй, 1 бункер нь 12м³ шороо орно. Бункер шороо дамжуулах үүрэгтэй. Бункерээс туузан дамжуургаар дамжин эргэлдэгч барбон уруу орно. Материалаа халаахын тулд мазут ашиглаж эргэлдэгч барбонд гал өгнө.
2. Эргэлдэгч барбоны дээр байрлах 2 циклон нь эргэлдэгч барбон доторхи материалын утааг шүүж яндан уруу өгнө. Яндан уруу сорогдох явцад усан филтерээр шүүгдэн цэвэрлэгдэнэ.
3. Усан ванн нь ус утаан дундуур гарахдаа утаанд байгаа том ширхэгтэй тоос тороог шүүж авч үлдэнэ. Шүүж авч үлдсэн байгаа тоос шороо эхний банн –д үлдэж дараагын банн уруу цэвэр ус нь орно. Орсон цэвэр уснаас филтерлүүгээ насос нь усаа эргэлдэх журмаар татна. 3 ванн буюу филтер нь агаарт цацагдах утааг цэвэршүүлж шүүх үүрэгтэй.
4. Эргэлдэгч барбанд халсан материал элеватороор (Шанагт дамжуулагч) Тээвэрлэгдэж шигшүүр үрүү орно.
5. Шигшүүр нь 4 төрөл байдаг. 0-5мм, 5-10мм, 10-20мм, 20-40мм
6. Шигшигдсэн материал тус тусын бүлэгээр хувиарлагдаж пүнкер үрүү унана.

7. Хувиарлагдсан пүнкерээс материалаа орц ноормын дагуу стандарт хэмжил зүйгээр баталгаажсан пүүгээр (дозотор) хэмжиж материалаа татна.
8. Материалаа татсаны дараа тусгайлан хадгалсан эрдэс нунтагаа сийлүүснээс (хадгалах сав) элеватороор (шанаган дамжуулагч) тээвэрлэгдэн гулсуураар дамжин пүүрүү орно.
9. Материал, эрдэс нунтаг татагдсаны дараа 110-130⁰С халуунтай ажлын тогоонд байгаа битумыг тусгай насосоор шахаж пүүрүү татна.
10. Халаах процессыг 3-р “ДЦС” - тай хийсэн “Уурын Дулаан Эрчим Хүч Худалдах Худалдан Авах” гэрээний дагуу стандарт шаардлагыг хангасан халуун уураар хангана.
11. Бүх материал татагдаж дууссаны дараа мешаик буюу холигч уруу оруулж холино.
12. 5-н төрлийн материалаа 38 секундэд холиод эцсийн бүтээгдэхүүн болох Асфальтбетон гарна.
13. Хувиарлагч бункерт хураагдах материал байх ёстой хэмжээнээсээ хэтрэхэд тэр материалыг гадагшлуулах хоолой нь заводын ар талын хана дагуу 2 ш хоолой байна.

Операторын өрөө (Удирдах өрөө)

Үйлдвэрийн ажиллуулах удирдлага буюу компьютер (хянах самбар) байна. Энэ удирдлагаар үйлдвэрийг асаж, унтрах бүх үйл явцыг удирдаж ажиллуулна. Удирдаж ажиллуулах явцыг компьютероор (хянах самбар) баталгаажина. Үйлдвэрийн гэмтэл эвдэрлийн дуут дохио өгч мэдэгддэг.

Мазут

Мазут нь 50тн –ын 1 хадгалах тогоотой. Хадгалах тогоо нь тогоор буюу тенээр ажиллана. Ажил эхлэхийн өмнө ажлын тогоор мазутаа татна. Эргэлдэгч барбана уруу насосоор татна.

Битум

Битум нь 50тн – ын 9 н хадгалах тогоотой, ажлын хоёр тогоотой. Хадгалах тогоо нь тогоор буюу тенээр ажиллана. Ажил эхлэхийн өмнө ажлын тогоонд байх битумыг уураар халааж бэлэн байлгана. Үйлдвэр үрүү татаж байгаа битумыг тусгай насосоор татна. Үйлдвэр үрүү битумыг татах шугамг халуун байлгахын тулд уурыг ашиглаж шугамаа халаадаг.


Эрдэс нунтаг

Эрдэс нунтаг нь 1 хадгалах савтай. Шахагч машинаар эрдэс нунтагаа шахдаг бөгөөд 40 тн-ын багтаамжтай.

Дайрга болон элс

Үйлдвэрлэлд ашиглах дайрга нь 0-5мм, 5-10мм, 10-20мм гэсэн ширхэг бүхий 3 төрөл байдаг. Захиалгаар карьераар шууд авчруулдаг. Авчирсан материалаа отволдох буюу хураадаг. Ширхэгээр нь бүлэглэж хураасан материалаараа ковшоор пүнкеррүү ангилаж хийнэ.

Битумыг халуунаар хадгалах зориулалт бүхий тус бүр 50 тн ийн 7 ширхэг ган савыг газар дор байрлуулсан байдал



Зураг 6. Битум хадгалдаг ёмоксть

Битум хадгалах савны тодорхойлолтын тайлан

Д/Д	Үзүүлэлтүүдийн нэр	Үзүүлэлтийн тоо хэмжээ, утга
1	Савны марк	РГС-50
2	Савны төрөл	ДАЛД ХЭВТЭЭ
3	Савны материалын нэр	ГАН
4	Савыг хийсэн материалын тодорхойлолт	Ст-4
5	Савыг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрийн нэр, бэлтгэн нийлүүлэгчийн нэр	ОХУ
6	Савны эзэлхүүн м ³	50
7	Савыг угсрах орчны дээд, доод температур	-20 +30С
8	Савны ёроолын хийц	КОНУС БУЛАНТАЙ
9	Савны ханын хийц	ДАН
10	Ямар төрлийн бүтээгдэхүүн хадгалах зориулалттай хийгдсэн.	БИТУМ
11	Савны онцгой тодотгол	БИТУМ ТҮРХЛЭГТЭЙ, ДАЛД

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

“ЭКО АСФАЛЬТ” ХХК-ийн Асфальтбетоны үйлдвэр үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоож байгалийн хам бүрдлүүдтэй уялдуулан тодорхойлж доорх хүснэгтэд үзүүлэв.

**Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК
-ийн “Асфальтбетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
Нэг. Агаар орчин			
1.	Тоосжилт	- Тээвэрлэлт (элс, хайрга, асфальтбетон болон ахуйн хэрэгцээний бүх төрлийн хангамж, хог хаягдал)	- Улирлын чанартай, тархах хүрээ хомс, хатуу хучилттай замаар төслийн талбай хүрдэг.
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, утаа, угаар	- Автомашин	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр. Хог хаягдал			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	- Ахуйн болон шатах тослох материалын хаягдал - Бохир ус дамжуулах хоолойн бүрэн бус байдал - Хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас шингэн хог хаягдал асгарах	- Хөрс болон ургамал бохирдох магадлалтай. - Хур борооны усаар угаагдаж хөрс бохирдуулна.
Гурав. Хөрс			
3.1	Элэгдэл, эвдрэл,	- Явган жим, зам гарах, дагтарших, талхлагдах	-Хэмжээ хязгаарлагдмал -Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөгдөж болно -Хөрс эвдэрч элэгдэж болно. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.
3.2	Бохирдол	- Ахуйн хог хаягдал	-Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар өөрчлөгдөнө.
Дөрөв. Ургамал бүрхэвч			
4.1	Ургамлын талхлагдал	-Автомашин болон явган хүний зам, мөр	-Хэмжээ хязгаарлагдмал
4.2	Хордолт	- Ахуйн хог болон шатах тослох материалын хаягдал	-Ургамлын биомассын хэмжээ багасна - Ургамлан бүрхэвч эргэлт буцалтгүй устаж болно - Ургамлын генд өөрчлөлт орж болно
4.3	Талхлагдах	- Хүний хөл хөдөлгөөн, үйл ажиллагаанд байнга өртөж буй зөрөг зам, жим, - Ашиглалтын талбай, барилга объектуудын орчин	- Ургамлын төрөл зүйл устаж болно - Ургамлыг нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
Тав. Амьтан			
5.1	Хордолт	- Шатах тослох материалын болон ахуйн хаягдал	-Хөрсөн дэх бичил биетэн, шавьж хорхой үрэгдэж болно. -Амьтдын удамшил генд өөрчлөлт орох магадлалтай
Зургаа. Нийгэм эдийн засгийн орчин			
6.1	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	- Улсын төсөвт хувь нэмэр оруулах
6.2	Шинээр ажиллагсад авна	- Ажлын байр шинээр бий болно	- нутгийн иргэдийн ахуй амьдралд тус дөхөм үзүүлнэ. - Тогтмол бус

Төслийн гол сөрөг нөлөөлөл

Байгаль орчин, хүн ам ба ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх болзошгүй нөлөөллийг судалж түүний агууриг, эрчим, байршлыг нь тогтоосон дээрх судалгаануудаас үзэхэд “ЭКО АСФАЛЬТ” ХХК-ийн Асфальтбетоны үйлдвэрийн үйл ажиллагааны хувьд ажлын байрны чимээ шуугиан, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг эрүүл ахуйд бичил орчны нөлөөлөх байдал нь голлох нөлөөлөлд хамаарахаар байна.

Голлох нөлөөллийг тодорхойлохдоо:

1. Гарч болох бохирдлын түвшинг харгалзан үзэх
2. Сөрөг нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг эрж хайхад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх
3. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмж боловсруулж өгөх явдал юм.

Мөн түүнчлэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх гол нөлөөллийн мөн чанар, бохирдлын болон болзошгүй ослын хэмжээ, үргэлжлэх хугацаа, хамаарах хүчин зүйл, хамрах хүрээ зэргийг зааж өгөх шаардлагатай байдаг.

Байгаль орчны бүрдэл хэсгүүдээс нөлөөлөлд өртөх гол бүрдэл хэсэг нь хөрс, ургамал байхаар байна. Иймд төслийн зөвлөмжид дурдсан болон хууль эрхзүйн баримт бичгийг байнга мөрдөн ажиллах хэрэгтэй.

Голлох нөлөөллийн хамрах хүрээ, эрчмийг нэгтгэж доорх хүснэгтэд харуулав.

Гол нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, хугацаа

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Хугацаа
1	Ахуйн бохир ус, хатуу хог хаягдлын угаагдал хөрсөнд шингэх	Орчны хөрс, хөрсний ус	0-1 га	Боломж бага	Хавар, намар, зуны улиралд
2	Зам, жим харгуй ихсэх	Хөрс, ургамал	Төслийн автомашины зогсоолоос гадна машин тэрэг байрлуулах	Их	Төслийн туршид
3	Түймэр	эд хогшил, ургамал, хөрс	0-10км ² түүнээс их	Хүчтэй	Тогтоох боломжгүй

Иймд эдгээр нөлөөллийг бууруулах, арилгах талаар БОННУ –ний тайланд өгсөн зөвлөмжүүдийг нэг бүрчлэн хэрэгжүүлж, цаашид байгаль хамгаалах жил бүрийн төлөвлөгөөнд тусган зохих арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч байх шаардлагатай.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2022 ОНЫ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалын “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дөрөвдүгээр зүйлд заасан “Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах” төрөлд багтдаг.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор гаргаж, харьяалагдах аймаг, нийслэлийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90 оноо хүрээгүй буюу, хангалтгүй гэж дүгнэгдсэн бол хангалтгүй хийгдсэн ажлыг дараа оны эхний улиралд багтаан гүйцэтгэсэн тохиолдолд дүгнэлтийг дахин гаргуулна. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн ажлыг дутуу хийсэн бол үүнд хамаарахгүй.

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Эко асфальт” ХХК нь холбогдох байууллагатай харилцан уялдаатай ажилладаг ба тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар болон зөрчлүүдээ цаг тухайд нь арилган ажилладаг болно. Манай компани нь Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2023 онд нийт 14 220 550 мян.төгрөгийг зарцуулаа. Энд тусгагдаагүй зардлууд нь үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно.

2023 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	хамрах хүрээ	Хариуцах албан тушаалтан	Тайлант зардал мян.төг	Биелэлт
1. Агаар орчин					
	Төслийн үйл ажиллагааны машин механизмдын хөдөлгөөнөөс үүсэх тоосны хэмжээг багасгах	Үйлдвэрийн талбайд	Үйлдвэрийн менежер П.Ганболд	420,0	Төслийн асфальт бетон хольцоос гарсан хог хаягдлаар авто машины зогсоол, мөн гарах орох зам, засмал зам хүртэл хайрган болгож өгсөн.Хайрган замаа усжуулалттай болгосон.
	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэх	Үйлдвэрийн ойр орчимд	Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан.	2023 оны 10 сарын 21-ны өдөр хийлгэсэн.
2. Хөрс, ургамлын бүрхэвч					
	Хөрсөнд шатах тослох материал асгарч бохирдохоос урьдчилан сэргийлэх	Үйлдвэрийн эргэн тойронд	Үйлдвэрийн менежер П.Ганболд	350,0	Хөрсөн дээр шатах тослох материал асгаж хөрс бохирдуулахаас сэргийлж үйлдвэрийн орчинг хайрган хучилттай болгосон.
	Нийт зардлын хэмжээ /мян.төг/			770,0	



Зураг 7. Үйлдвэрийн эргэн тойрон

3.2 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

3.3 Болзошгүй аюул, ослын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй эрсдлээс хамгаалах зардал

Арга хэмжээ	Эрсдлээс хамгаалах арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Тайлант зардал /мян.төг/	Биелэлт
Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Материалын инженер О.Алтан-өлзий	2,000,0	ХАБЭА, аюулгүй ажиллагааг хангаж ажиллан, өглөө бүр ажилчдад зааварчилгаа өгдөг ба эрсдэл тохиолдсон үед галын аюулаас хамгаалах булан хамгаалах гал унтраах хэрэгслийг бэлэн байрлуулсан. Мөн ХАБЭА самбар, зааварчилгааг хадгаж байрлуулсан.
Техник тоног төхөөрөмжинд	Машин механизм, техникийн аюулгүй байдлыг шалгах, хянах	Үйлдвэрийн менежер П.Ганболд	6,500,0	Үйлдвэрийн ажилтнууд ажил эхлэхээс өмнө үйлдвэрийн машин механизмын аюулгүй байдал, хэвийн ажиллагааг өдөр бүр шалгадаг. Мөн долон хоног бүр машин механизмын тос тосолгоо үйлчилгээг хийдэг. Шаардлагатай сэлбэг хэрэгсэл, тос тосолгооны материалыг баталгаатай газраас худалдан авч тавьдаг. Техник ашиглалтын паспорт дээр бүртгэл хөтөлдөг.
Нийт төсөв /мян.төг/			8,500,0	

3.4 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

“Асфальтобетон хольцын үйлдвэр” төслийн үйл ажиллагаатай холбогдож гарах хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтыг оновчтой шийдвэрлэх зорилгоор журам боловсруулж мөрдөж эхлээд байна. Уг зорилтын хүрээнд хог хаягдал, байгаль орчны талаарх Монгол Улсын хууль, бодлого шийдвэр, дүрэм журмын дагуу боловсруулсан болно. Бид өөрсдийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын хэмжээг хамгийн бага байлгах, дахин ашиглагдахгүй хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор устгах ач холбогдол өгч ажилладаг.

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Хаягдлын төрөл	Хийгдсэн арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан	Тайлант зардал /мян.төг/	Биелэлт
Ахуйн хог хаягдал	Ахуйн хог хаягдлыг ил задгай хийсэх, байгаль орчин бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээ авах Хог хаягдал хадгалах зориулалтын хогийн савыг 2-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байх	Нягтлан бодогч Г.Мөнхзул	120,0	Зориулалтын цэг байгуулж, хог хаягдлыг 1.Дахин боловсруулах 2.Ахуйн гэсэн 2 төрлөөр ангилан ялгах хогийн саваа хаягжуулан тусгай хогийн цэг байгуулж байрлуулан тавьсан.
	Ахуйн хог хаягдлыг холбогдох байгууллагатай гэрээ хийж, тогтмол хугацаанд зайлуулдаг.	Нягтлан бодогч Г.Мөнхзул	2 x 85.0 = 170,0	Хогийн савыг өнгөөр ялгаж, тэмдэгжүүлж, байршуулсан.
	Байгаль орчинд хортой хог хаягдал гарахаас сэргийлэх	Материалын инженер О. Алтан-өзий	3 x 136850=410,550	Хан-Уул дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан ахуйн хог хаягдалаа хоёр сард нэг ачуулдаг. Хог ачилтаа 1удаадаа 136850 төг ачуулдаг
Шингэн хаягдал	Усан яндангаас үүсэх илүүдэл лагийг зайлуулах	Материалын инженер О. Алтан-өзий	1,500,0	Байгаль орчинд хортой хог хаягдал гарахаас урьдчилан сэргийлж, үйлдвэрлэлийн технологийн горимыг баримталж ажилладаг. Үйлдвэрлэлтэй холбоотой байгаль орчинд хортой хатуу хог хаягдал гардаггүй.
Нийт /мян.төг/			2,200,550	Усан яндангаас үүссэн илүүдэл лагийг “ӨРГӨЖИХ ХАУС” ХХК-тай гэрээ байгуулан сар бүр соруулдаг.



Зураг 8.Ахуйн хог хийх хогийн сав



Усан яндангаас үүссэн лагийг соруулах

3.5 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	хамрах хүрээ	Хариуцах албан тушаалтан	Тайлант зардал мян.төг	Биелэлт
1	Хоосон талбайд цэцгийн мандал байгуулсан. Зүлэгжүүлэх мод тарьсан	Үйлдвэрийн эргэн тойронд	Нягтлан бодогч Г.Мөнхзул	1,200,0	9ш цэцгийн мандалд наранцэцэг, нэг наст цэцгийн үрсэлгээ, 10ш моносны мод, 5ш бутлаг мод тарьсан
2		Нийт дүн		1 200,0	



Зураг.9 цэцгийн мандал

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК-ийн “Асфальтобетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Манай байгууллагад улс нийслэлийн хэмжээний тэрбум мод төсөлөөс ХУД-ийн 14-р хороонд байрлах Өлзийт хороололын урд талбайд



Суулгасан модоо усалсан байдал 2023оны 4н сард:



Зураг 10. Модоо усалж арчилав

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК -ийн “Асфальтобетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Манай байгууллагад улс нийслэлийн хэмжээний тэрбум мод төсөлөөс ХУД-ийн 13-р хороонд байрлах Шувуун фабрикийн зам дагуу талбайд 2дахь удаагаа мод тарж оролцож бна.



№	Нэр	Тайлант зардал мян.төг	Тоо ширхэг/гн
1	Хар шороо	250,000	3тн
2	Мод	1,000,000	20ш
3	Бусад	300,000	Хоол түлш
4	Нийт	1,550,000	



3.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хийгдэх үйл ажиллагаа	Хамрах хүрээ	Хариуцах албан тушаалтан	Тайлант зардал мян.төг	Биелэлт
Байгууллагын дотоод журам, санхүүгийн үйл ажиллагаа					
1	Ажлын цагийн бүртгэл, цаг ашиглалт	Төслийн бүх ажилчдад	Нягтлан бодогч Г.Мөнхзул	100,0	Ажилчид ажил эхлэх болон тарахад автомат цаг бүртгэлийн машинд бүртгүүлдэг ба давхар цаг бүртгэлийн дэвтэрь Сахиул Ч.Бодьхүү ажлын цаг бүртгэлийг бүртгэж сард 2 удаа Нягтлан бодогч Г.Мөнхзулд өгдөг. Ажлаас чөлөө
2	Ажил үүргээ гүйцэтгэж байгаад хяналт тавих	Бүх ажилчдад	Удирдах албан тушаалтнууд	-	Дотоод хяналтын баг нь тогтоомол болон гэнэтийн шалгалт явуулж, үр дүнг газар дээр нь засах буюу удирдлагад танилцуулан арга хэмжээ авдаг журамтай.
3	Газрын хянан баталгаа хийлгэх	Төслийн талбайд	-	1,500,0	2020 онд хийлгэсэн.
Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа					
1	Үйлдвэрийн ажилчдын ажил үүргээ бүрэн гүйцэтгэж байгаад хяналт тавих	Бүх ажилчдад	Удирдах албан тушаалтнууд	-	Ажилтнууд өөрсдийн хариуцсан ажил үүргээ гүйцэтгэж байгаа байдалд дотоод хяналтын баг хяналт тавихаас гадна багийн хяналт тавигддаг. Захирал дуртай үедээ дуртай газраас хяналт тавих камерын хяналтын системтэй.
2	Үйлдвэрлэлийн технологийн горим мөрдөлт	Ажилчдад	Материалын инженер Г. Мягмаржав Үйлдвэрийн менежер П.Ганболд	-	Үйлдвэрлэлийн технологийн горим мөрдөлт байгаа байдалд дотоод хяналтын баг хяналт тавихаас гадна багийн хяналт тавигддаг. Захирал

						дуртай үедээ дуртай газраас хяналт тавих камерын хяналтын системтэй. Удирдах албан тушаалтнууд үйлдвэрлэлийг материал, мөнгө санхүүгээр тасалдалгүй явуулах, үйлдвэрийг гэнэтийн эвдрэл, гэмтэлээс хамгаалах эрсдлийг тооцоолон ажилладаг.
3	Үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах	Ажилчдын	Удирдах албан тушаалтнууд			Материалын инженер О.Алтан-Өлзий нь үйлдвэрлэлийн түүхий эдийн чанар байдал, хангамжийг хариуцан ажилладаг.
4	Үйлдвэрлэлийн түүхий эдийн чанар байдал, хангамж	Түүхий эд Элс, хайрга	Материалын инженер О. Алтан-өлзий			Үйлдвэр ажиллахад нэгэн жигд халах горимтой доголдох эрсдэл буурах
5	Галын автомат системтэй болсон	Үйлдвэрт	Операторчин Р. Жигждорж			
ХАБЭА ажиллагаа						
1	ХАБЭАхуйн нийт ажилтны сургалтанд хамруулах	нийт ажилтнууд	Материалын инженер О. Алтан-өлзий	2,000,0		МАЗУЭХолбооны "Хөгжлийн хөтөч" сургалтын төвөөс зохион байгуулсан Б. Цэрэнпүрэв багштай Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй" сэдэвт 1 өдрийн сургалтанд байгууллагын бүх ажилтнууд оролцож сургалтын дараа шалгалт өгч гэрчилгээ авсан.
2	ХАБЭА-н ажил олгогч эздийн сургалт	захирал	Захирал Д.Батболд	150,0		МАЗУЭХ-той гэрээ хийж ХАБЭА-н давтан сургалтанд суусан
3	ХАБЭА талаар өдөр тутмын зааварчилгаа өгөх	байгууллагын хэмжээнд	Материалын инженер О. Алтан-өлзий Үйлдвэрийн менежер П.Ганболд			ХАБЭА-н зааварчилгаа өдөр тутам өгдөг.
4	ХАБЭАхуйн хувцас хэрэглэлээр хангах	нийт ажилтнууд	Няглан бодогч Г.Мөнхзул	9,000,0		ХАБЭА-н хувцас хэрэгслэлээр хангаж, ХАБЭА хувцас, хамгаалах хэрэгслэлээ өмссөн эсэхэд хяналт тавьж ажилладаг.
5						Дотоод хяналтын баг нь дотоод

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК -ийн “Асфальтобетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

	ХАБЭАхуйн хувцас хэрэглэлийн хангамж, хувцас хэрэглэлээ өмсөж ажиллаж байгаа талаар хяналт тавих	нийт ажилтнууд	Материалын инженер Г. Мянмаржав Үйлдвэрийн менежер П.Ганболд		хяналтын журмын дагуу гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалт хийж үр дүнг тухай бүрд удирдлагад танилцуулдаг.
6	Үйлдвэрлэлийн орчинд ХАБЭА тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Үйлдвэрийн хэмжээнд	Материалын инженер О. Алтан-өлзий	550,0	Үйлдвэрлэлийн орчинд ХАБЭА -н тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан
7	Галын булан байгуулах	Үйлдвэрийн хэмжээнд	Материалын инженер О. Алтан-өлзий	520,0	Үйлдвэрийн орчныг галын аюулаас хамгаалах самбар, галын буланг хийж байрлуулсан. Өндөр хүчдэлээс хамгаалах самбар, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. Галын аюулаас хамгаалах заавар, галын хор, хүрз, элс зэргийг галын буланд байрлуулсан.
8	Ажилчдыг эрүүл ахуйн үзлэг шинжилгээнд хамруулах	нийт ажилтнууд	Нягтлан бодогч Г.Мөнхзул	-	Нийт ажилчдыг 5-н сард төлөвлөгөөт үзлэгт оруулах байсан боловч Корона вирусийн тархалт их байгаа тул эмнэлэгийн байгуулгаар үйлчлүүлэхэд халдвар авах эрсдэл их байгаа тул төлөвлөгөөт үзлэгээ түр хойшлуулсан.
9	Ажлын байрны эрүүл аюулгүй,цэвэр орчинг ханган ажиллах	нийт ажилтнууд	Сахиул Ч.Бодьхүү	900,0	Сар бүр саван, угаалгын нунтаг, жавелин, хлорамин зэрэг ариутгал цэвэрлэгээний бодис, 1 удаагийн аяга, нойтон хуурай сальфетка авч, өдөр тутмын цэвэрлэгээ ариутгалыг сахиул Ч.Бодьхүү хариуцан гүйцэтгэдэг. Сар бүр "Ариун нар сар" ХХК-аас ирж оффис ажилчдын амрах байр болон үйлдвэрийн орчинд ариутгал хийдэг.
10	Ажлын хувцасыг угааж цэвэрлэх	нийт ажилтнууд	нийт ажилтнууд	1,000,0	Ажилчид ажлын хувцас хэрэглэлээ угаалгын өрөөнд угаах болон халуун усанд орж биеэ угаах боломж нөхцөлөөр хангасан.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК-ийн “Асфальтобетон хольцын үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Цэвэрлэгээ ариутгал				
№	Төслийн талбайд	Сахиул Ч.Бодьхүү	Ажилтнууд хог хаягдалын хуулийн дагуу хогоо ангилан ялгаж, зориулалтын саванд хаяж хэвшсэн.	Ажилтнууд хог хаягдалын хуулийн дагуу хогоо ангилан ялгаж, зориулалтын саванд хаяж хэвшсэн.
1	Үйлдвэрлэлийн хашаан доторх хог хаягдалын менежментийг ханган ажиллах	Сахиул Ч.Бодьхүү		
2	Ажилчдын хувийн ариун цэвэр, халдвар хамгааллыг хангаж ажиллаж байгаа эсэх	Нийт ажилтнууд		Ажилчдын хувийн ариун цэвэр, халдвар хамгааллыг хангаж, угаалгын өрөөнд хувцасаа угаах болон халуун усанд орж биеэ угаах боломж нөхцөлөөр хангасан.
3	Бие засах газрын ариун цэвэр халдвар хамгааллыг ханган ажиллаж байгаа эсэх	Нийт ажилтнууд		Ажилчдын бие засах өрөөг тогтмол ариутгал цэвэрлэгээ хийж байгаа байдалд Нягтлан бодогч Г.Мөнхзул хяналт тавьж ажилладаг. “Ариун нар сар” ХХК нь гэрээний дагуу ирж ариутгал шавьж устгалыг хийдэг.
Асфальт зуурхад хор тайлхад өгдөг бүтээгдэхүүн				
1	Сүү, аарц, ундаа	Материалын инженер О. Алтан-өлзий Үйлдвэрийн менежер П.Ганболд Нягтлан бодогч Г.Мөнхзул	1,000,0	Асфальт зуурсан өдөрт хүн тус бүрд 1 литрээр бодож олгоно
2	Халуун чацаргана, аарц, сүү	Материалын инженер О. Алтан-өлзий Үйлдвэрийн менежер П.Ганболд Нягтлан бодогч Г.Мөнхзул	1,000,0	Асфальт зуурсан өдөр хүн тус бүрд 1 литрээр бодож олгоно шөнө болон хүйтэн өдрүүдэд халуун уух зүйлээр хангана
3	Нийт дүн		17 720 000	

3.7 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал

Шинжилгээний нэрс	Шинжилгээ хийлгэсэн лаборатори	Хийлгэсэн тоо	Нэгж үнэ	Тайлант зардал /мян.төг/
Агаарын хяналт шинжилгээний хөтөлбөр				
1	Тоосонцор-PM10, PM2.5 Хүхэр, азот (бага эзэлхүүний арга)	1	-	130.0
2	Дуу чимээ	1	-	
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөр				
1	Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүд	1 зүсэлт 3 Дээж	25.0	75.0
2	Хөрсний хүнд металл	1 зүсэлт 1 Дээж	35.0	35.0
Нийт дүн				240,0

3.8 2020 оны БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах мэдээ

БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Хорооны ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	Хурал 11-р сард зохион байгуулах бололцоотой	Хурлын заал

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН НЭГДСЭН ДҮН

Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардлын нэгдсэн дүн


Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ мян/төг
1	Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	мян төг	770,0
2	Нөхөн сэргээлтийн зардал	мян төг	1,550,0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	мян төг	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	мян төг	-
5	Болзошгүй эрсдлээс хамгаалах зардал	мян төг	8,500,0
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	мян төг	2 200,550
7	Удирдлага-зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ	мян төг	17,720,000
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	мян төг	240,0
9	БОМТ-г орон нутагт тайлагнах		-
10	Тэр бум мод төсөлд	мян төг	1,300,000
	Дүн		32 280 550


ДҮГНЭЛТ

“Асфальт бетон хольцын үйлдвэр” төслийн хүрээнд 2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 32 280 550 төгрөгийн зардал гаргасан байна.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Эко асфальт” ХХК -ийн “Асфальтобетон хольцын үйлдвэр”
төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хоргүйжүүлэх ундаа сүү нийт ажилчид.





**ХӨРС СУДЛАЛЫН
ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**



ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn

Дугаар: 23/2102

Дээж авсан огноо: 2023 он 10 сарын 12

Шинжилгээ хийсэн огноо: 2023 он 10 сарын 16-17

Дээж авсан газрын нэр: Улаанбаатар хот, ХУД, 3-р цахилгаан станцын баруун талд

Координат: -

НДТ: -

Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “Эко Асфальт” ХХК

Харилцах утас: 99605041 99060000

Хөрсний химийн задлан шинжилгээний дүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, dbm	Ялзмаг, %	NO ₃ мг/100г	CaCO ₂ %	Шингээгдсэн сууриуд мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
										Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
0	1	2	3	4	5	6	7	8	10	11	12	13	14
1	23/5525	Дээж-1	-	7.95	0.17	0.378	0.65	0.38	0.00	9.6	5.4	1.1	10

Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм						
				1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	23/5525	Дээж-1	-	52.4	27.9	8.5	2.8	7.9	0.5	11.2

Хөрсний хүнд металл

№	Лаб №	Дээжний нэр	Гүн, см	Хүнд металл мг/кг					
				Ni /Никель/	Cd /Кадми/	Pb /Хар тугалга/	Cu /Зэс/	Zn /Цайр/	Cr /Хром/
1	23/5525	Дээж-1	-	17.1	ND	15.8	8.74	35.6	11.7
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/				150,0	3,0	100,0	100,0	300,0	150,0
Хортой агууламж /MNS 5850:2019/				1000,0	10,0	500,0	500,0	600,0	400,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/				1800,0	20,0	1200,0	1000,0	1000,0	1500,0
Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт				/MNS 5850:2019/					

*ND-not detect

Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Шинжилгээ хийсэн арга стандарт:

(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020, MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч:  Л. Цагаандархи /MS.c/ - 1,
Задлан шинжээч:  О. Дагвийжамал /MS.c/



Хавсралтууд

1. ДЦС-Зын уурын дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэх гэрээ
2. Хан-Уул дүүрэгийн хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ
3. УСУГ гадны тээврийг усаар хангах гэрээ
4. Бохир ус соруулах гэрээ /Өргөжих хаус ХХК/
5. Төлбөр төлсөн баримт/ өнгөт зураг/-ны хамт
6. Хаягдал усны дүгнэлт



Л.ЭРХБААТАР



**УУРЫН ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР
ХАНГАХ, ХЭРЭГЛЭХ ГЭРЭЭ**

2023 оны 02 сарын 07 өдөр

№ 1-5-78/23

Улаанбаатар хот

Нэг талаас "ДЦС-3" ТӨХК /цаашид "Хангагч" гэх /-ийг төлөөлж Ерөнхий инженер ажилтай П.Болдбаатар, нөгөө талаас "БИ ТИ ӨҮ" ХХК-ийн /цаашид "Хэрэглэгч" гэх/ Нягтлан бодогч ажилтай Б.Мөнхзул нар Монгол Улсын иргэний Хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд харилцан тохиролцож, хангагч нь стандартын шаардлага хангасан уураар хангах, хэрэглэгч нь хэрэглэсэн уурын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэг хүлээж энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн харилцааг зохицуулах, гэрээний нөхцөл, тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, эрчим хүчний чанар, тоо хэмжээ, төлбөр тооцооны нөхцөл, хангагч хэрэглэгчийн эрх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд гэрээний зорилго оршино.
- 1.2. Талууд Монгол улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос тогтоосон үнэ тариф, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм зэргийг үндэслэн гэрээ байгуулав.
- 1.3. Хэрэглэгч нь зохих журмын дагуу техникийн нөхцөл авсан, эрчим хүчээр хангах гэрээний нөхцлийг харилцан тохиролцож зөвшөөрсөн, урьд нь хэрэглэсэн эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй, барьцаа төлбөр байршуулсан байна. Барьцаа төлбөрийг гэрээ цуцалсны дараа эргүүлж олгоно. Хэрэглэгч нь төлбөрөө 2-оос дээш сараар төлөөгүй, удаан хугацаагаар зогссон тохиолдолд барьцаа төлбөрөөс уурын төлбөрт шилжүүлэн суутгаж болно.
- 1.4. Энэхүү гэрээгээр хэрэглэгч нь **2023 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал** хугацаанд эрчим хүчээр хангагдана.
- 1.5. Энэхүү гэрээ нь дараагийн гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Хангагчийн эрх, үүрэг

- 2.1. Хангагч нь Монгол Улсын иргэний Хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч -Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм, хангагч хэрэглэгчийн хоорондын аж ахуйн гэрээ болон бусад хууль, тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

- 2.2. Хангагч нь эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, газар эзэмших гэрчилгээ зэргийг үндэслэн уурын дулааны эрчим хүчээр хангах гэрээг байгуулах үүрэгтэй.
- 2.3. Хангагч нь чанар, стандартын шаардлага хангасан уурын дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах үүрэгтэй.
- 2.4. Хангагч нь хэрэглэгчийн баталгаажсан тоолуур хэмжих хэрэгслийн заалтыг үндэслэн уурын дулааны эрчим хүчний хэрэглээг тооцож, төлбөрийн нэхэмжлэхийг өгч, төлбөрийг авах үүрэг хүлээнэ.
- 2.5. Дулааны сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, норм, нормативын дагуу чанартай хийх, хэрэглэгчдэд мөн адил шаардлага, хяналт тавих үүрэгтэй.
- 2.6. Хангагч нь Хэрэглэгчийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийн ашиглалт, ААД-ийн хэрэгжилт, уурын дулааны эрчим хүчний төлбөрийн төлөлт, тоолуур хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаатай байгаа эсэхийг шалгах зорилгоор барилга байгууламжид нь нэвтрэн орох, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай шаардлага, акт тавих, мэдэгдэл өгөх эрхтэй.
- 2.7. Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Хангагч нь Эрчим хүчний тухай хууль болон энэхүү гэрээний 5.1-д заасны дагуу хэрэглэгчийн эрчим хүчний хангамжийг түдгэлзүүлж, зөрчлийг арилгахыг шаардах эрхтэй. Зөрчил арилсан тухай бүр хэрэглэгчийг эрчим хүчээр саадгүй хангах бөгөөд хэрэглэгчийн буруугаас таслах, залгахад гарсан зардлыг хэрэглэгч хариуцна.
- 2.8. Шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан хэрэглэгчийг эрчим хүчээр хангахаас татгалзах эрхтэй.
- 2.9. Хангагч нь хэрэглэгчийн хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, хэмжих хэрэгслийн туршилт тохируулга, шалгалт, баталгаажуулалтыг хугацаанд нь бүрэн хийлгэж, түүнд хяналт тавьж, зөрчлийг арилгуулан хэмжүүрийн үнэн зөв байдлыг хангуулах үүрэгтэй.
- 2.10. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд эрчим хүчний төлөвлөгөөт тасралт (урсгал засвар, өдөр тутмын гэмтэл, саатал)-ын улмаас гэрээнд заасан эрчим хүчээр хангахгүй болсон тухайгаа хэрэглэгчид 4-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэнэ. Станцын бүрэн зогсолтын үед хийгдэх их засварын ажлыг гүйцэтгэхдээ хэрэглэгчдэд 7 хоногийн өмнө албан мэдэгдэл өгөх үүрэгтэй.
- 2.11. Хэрэглэгчээс техникийн нөхцлөө сунгуулах, шинэчлэн гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж хариуг өгнө.
- 2.12. Хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр уурын дулааны эрчим хүчээр хангах гэрээ байгуулахаас татгалзах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.
- 2.13. Хангагч нь эрчим хүчний үнэ, тарифт орох өөрчлөлтийг тухай бүрт нь хэрэглэгчид мэдэгдэх үүрэгтэй.

Гурав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 3.1. Эрчим хүч хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч -Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм, хангагч хэрэглэгчийн хоорондын аж ахуйн гэрээ болон бусад хууль, тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 3.2. Хэрэглэгч нь аж ахуйн гэрээ байгуулахын тулд өөрийн хөрөнгөөр тоолуур хэмжих хэрэгслийг суурилуулж, өөрийн эзэмшлийн шугам тоноглол, хэмжих хэрэгсэлд шахалт, шалгалт, туршилт, угаалга хийсэн баримтын бүрдлийг хангасан байхын зэрэгцээ технологийн уур хэрэглэх угсралтын схем, агаар гаргагч, юүлэгчийн угсралтын зургийг төслийн дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн зургийг хавсаргахын хамт хоногийн, цагийн ачааллын график, нийт хэрэгцээг тодорхойлсон тооцоог хавсаргана.
- 3.3. Хэрэглэгч нь эрчим хүчний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.4. Хэрэглэгч нь нэр, хаяг, байршил, харилцах банк, дансны дугаар өөрчлөгдвөл энэ тухайгаа ажлын 1 хоногийн дотор хангагчид мэдэгдэх ба бусдад шилжүүлсэн бол 7 хоногийн дотор төлбөр тооцоог хийж дуусгах үүрэгтэй.

- 3.5. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэмжүүрийн ашиглалт, найдвартай ажиллагааг хангах үүднээс үзлэг үйлчилгээ, суурилуулах, баталгаажуулах, шалгуулах, хэмжүүрийн бүрэн бүтэн байдал, ашиглалт, засвар үйлчилгээг өөрийн хөрөнгөөр, мэргэжлийн байгууллага, ажилтнаар хийлгэнэ.
- 3.6. Хэрэглэгч нь авч буй уурыг алдагдалгүй үр ашигтай хэрэглэх үүрэгтэй бөгөөд гарсан алдагдлыг нөхөж төлнө.
- 3.7. Эрчим хүчээр хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр уурын дулааны эрчим хүчний хангамжийг тасалдуулсан, гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын үзүүлэлт бүхий эрчим хүчээр хангаагүй бол нийлүүлээгүй буюу дутуу нийлүүлсэн эрчим хүчний үнийн дүнгийн 5 хүртэл хувьтай тэнцэх торгууль төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй.
- 3.8. Хэрэглэгч нь илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор хангагчаас тавьсан акт, шаардлага, мэдэгдлийн заалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 3.9. Энэ гэрээний 5.1, 5.2-д зааснаас бусад үндэслэлээр эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлснээс учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.
- 3.10. Хангагчтай тооцоо хийдэг тоолуур хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ажиллагааны байдалд өдөр бүр хяналт тавьж ашиглалтыг бүрэн хариуцаж гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэнэ.
/Эрчим хүчний хангамжтай холбоотой асуудлаар – 11-343097/
- 3.11. Эрчим хүчний улсын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтны тавьсан лац, ломбо, бусад битүүмжлэлийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.
- 3.12. Хэрэглэгч өөрийн хүсэлтээр уур нээлгэх, хаалгах тохиолдолд 3 хоногийн өмнө албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- 3.13. Хэрэглэгч нь өргөтгөл шинэчлэл хийх, барилга байгууламжид дулааны эрчим хүч авах, ачааллыг өөрчлөх болон дулааны тоног төхөөрөмж, шугам сүлжээ, халаалтын системийн техникийн шийдлийг өөрчлөх, технологийн шинэчлэл хийх тохиолдол бүрт хангагчаас техникийн нөхцөл шинээр авна.
- 3.14. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гэрээнд заасан эрчим хүчийг авахгүй болсон тохиолдолд энэ тухайгаа хангагчид 7 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 3.15. Хангагчийн зөвшөөрлөөр өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбуулах үүрэгтэй.
- 3.16. Уурын шугам хоолой, тоног төхөөрөмж, шугам сүлжээний ашиглалт, засварыг хариуцах мэргэжлийн ажилтныг томилж ажиллуулах, тэдгээрийн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх. Дулааны тоног төхөөрөмжийн ашиглалт, засварыг мэргэжлийн бус хүнд хариуцуулахыг хориглоно.
- 3.17. Хэрэглэгч нь уурын тоолуур хэмжих хэрэгсэл суурилагдсан орчныг эмх цэгцтэй, цэвэр, байнгын гэрэлтүүлэг, дулаацуулга, агааржуулалттай, засвар үйлчилгээ хийх боломжтой зориулалтын узель /тусгаарлах өрөө/-ээр хангана. Узелийг орон байр, агуулах болон бусад зориулалтаар ашиглахгүй байна.
- 3.18. Хэрэглэгч нь уурын тоолуур, хэмжих хэрэгслийн цахилгааны тэжээлийг найдвартай эх үүсвэрээс холбож, хүчдэл давтамжийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмжөөр тоногдосон байна.
- 3.19. Хэрэглэгч нь технологийн уур хэрэглээгүй үедээ тоолуурын өмнөх таслах хаалтыг бүрэн хааж, шугам хоолойг юүлсэн байна.
- 3.20. Хэрэглэгчийн уурыг хэмжиж байгаа тоолуур хэмжих хэрэгсэл ашиглалтын явцад эвдрэл гэмтэл гарсан, ээлжит баталгаажилтад тэнцээгүй тохиолдолд тоолуур хэмжих хэрэгслийг ажилд оруулах зардлыг хэрэглэгч бүрэн хариуцна.
- 3.21. Хэрэглэгчид суурилагдсан тоолуур хэмжих хэрэгслийг Стандартчилал Хэмжил Зүйн газарт баталгаажуулах баталгаажуулалтын төлбөрийг хэрэглэгч хариуцна.
- 3.22. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд эрчим хүч хэрэглэх гэрээ байгуулах, сунгуулахдаа дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.22.1. Шинэ хэрэглэгч хангагчаас техникийн нөхцөл авах, хуучин хэрэглэгчийн техникийн нөхцлийн үйлчлэх хугацаа хүчинтэй байх.

3.22.2. Эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй байх

3.22.3. Барьцааны төлбөрийг төлсөн байх

3.22.4. Хэрэглэгч аж ахуйн нэгж, байгууллага нь гэрээ хийх, сунгуулах тухай бүрд өөрийн байгууллагын гэрчилгээний хуулбарыг гэрээнд хавсаргасан байх.

3.22.5. Гэрээнд хавсаргах бусад материалуудыг бүрэн бүрдүүлсэн байх.

3.23. **Жил бүрийн 6-р сарын 20-ны дотор** дараа жилийн уурын дулааны эрчим хүчний хэрэглээний захиалгыг хангагчид гаргаж өгөх үүрэгтэй.

Дөрөв. Төлбөрийн нөхцөл, торгууль ноогдуулах

- 4.1. Хэрэглэгч нь тухайн сарын захиалгын дагуу авах дулааны эрчим хүчний үнийн дүнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг хангагчийн дансанд хийж байршуулсны дараа эрчим хүчээр хангана.
- 4.2. Хангагч нь хэрэглэгчийн хэрэглэсэн эрчим хүчний бичилтийг сард нэг удаа хийх бөгөөд хэрэглэгч нь эрчим хүчний төлбөрийг хавсралтад заагдсан хугацааны дотор багтаан төлж барагдуулна.
- 4.3. Тоолуургүй хэрэглэгчийн дулааны тооцоог хийхдээ дулааны холболтын техникийн нөхцөлд заасан цагийн ачааллыг үндэслэн, амралтын өдрүүдийг ажлын өдөрт тооцон, ажиллах цагийг 8-аар авч, үлдсэн 16 цагт нь цагийн ачааллын 30 хувиар бодож тооцно. Гэхдээ ажилласан цаг, ачааллыг дунджаас хэт өндөр ажилласан эсэхэд хяналт тавьсан албан тушаалтны дүгнэлтийг үндэслэнэ. Ажилласан хоногийг албан бичиг өгч уур хаалгаж, нээлгэсэн хугацаагаар тооцно.
- 4.4. Дулааны эрчим хүч хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгсэл гэмтэж ажиллагаагүй болсон, хэмжих хэрэгслийн тэжээлийг тасалсан тохиолдолд тооцоо хийхдээ уг хэмжүүрийн хэвийн ажиллаж байсан үеийн заалтыг үндэслэж нөхөж тооцно. Тоолуур хэмжих хэрэгсэл сүүлийн 3 сар хэвийн ажиллаагүй болон үйлдвэрийн ачаалал тогтмол биш байсан бол дулаан холболтын техникийн нөхцөлд заасан цагийн ачааллаар тооцож, тооцоонд авна.
- 4.5. Хэрэглэгч нь технологийн уур хэрэглээгүй /даралт, температур үүсээгүй/ үед тоолуурт зарцуулалтын хуурмаг заалт үүссэн тохиолдолд тоолуурын архиваас хуурмаг заалтыг хасаж тооцно.
- 4.6. Дулаан зөөгчийн үнийг **100%**-аар, Шугамын алдагдлыг **20%**-аар тооцно.
- 4.7. Тоолуур хэмжих хэрэгслийг СХЗГ-т магадлан шалгалтад оруулж шалгуулахад гарах зардлыг магадлан шалгалт хийлгэх хүсэлт тавьсан тал хариуцна.
- 4.8. Хэрэглэгч нь энэ гэрээний хавсралтад заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд Эрчим хүчний тухай хуулийн 31.3-д заасны дагуу хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0,5 хувьтай тэнцэх хэмжээний алданги оногдуулна.
- 4.9. Нийт алдангийн хэмжээ нь төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 50%-аас хэтрэхгүй байна.
- 4.10. Хэрэглэсэн эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол Эрчим хүчний тухай хуулийн 29,1.7 –д заасныг үндэслэн эрчим хүчээр хангах гэрээг цуцалж бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 4.11. “Дулааны эрчим хүчний төлбөр тооцох журам”-ын 3.11.-т заасны дагуу тухайн сард төлсөн төлбөрийг тооцохдоо урьд сард гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүй төлбөрийн үлдэгдэл болон алдангийг эхний ээлжинд төлснөөр тооцон суутгаж зөрүүг тухайн сарын төлбөрт тооцно.
- 4.12. Хэрэглэгч эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн болохыг хангагчийн эрх бүхий ажилтан илрүүлсэн бол нөхөн тооцоог суурилагдсан хүчин чадлаар нь тооцож, төлбөрийн хэмжээг тогтооно.
- 4.13. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийдэг ажилтны буруугаас гарсан зөрүүг гэрээт талууд харилцан тохиролцож, дараа сарын тооцоонд тайлбартайгаар тусгаж нөхөн тооцоог хийнэ.
- 4.14. Хангагчийн буруутай үйл ажиллагаанаас хэрэглэгчид хохирол учруулсан бол хоёр тал хамтран тогтоож баталгаажуулсан актыг үндэслэн хохирлын төлбөрийг хэрэглэгчийн уурын дулааны эрчим хүчний төлбөрөөс хасаж тооцно.

Үнэ тариф

- 4.15. Гэрээт талууд Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолоор баталсан үнэ тарифыг мөрдөж ажиллана.
- 4.16. Хангагч, хэрэглэгчийн хооронд хийх эрчим хүчний хэрэглээний төлбөрийн тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтыг үндэслэн батлагдсан тарифаар тооцно. Үнэ тариф өөрчлөгдсөн тохиолдолд хангагч нь хэрэглэгчид тухай бүр мэдэгдэнэ.
- 4.17. Хангагчаас хэрэглэгчид үзүүлэх зарим үйлчилгээг батлагдсан тарифын дагуу төлбөртэй гүйцэтгэнэ.
- 4.18. ЭХЗХ-ны Зохицуулагчдын зөвлөлөөс баталсан үнэ тариф өөрчлөгдөхөөс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр шинэчлэгдсэн үнэ тарифыг зарласан байх бөгөөд хангагчийн зүгээс хэрэглэгчид үнэ тарифын өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүрт хүргэнэ. Мэдээлэл хожимдох нь энэхүү үнэ тарифыг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.
- 4.19. Хэрэглэгчийн болон хангагчийн хүсэлтээр уурын дулааны эрчим хүчний хэрэглээг нээх, хаах үйлчилгээг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан төлбөрт үйлчилгээний үнэ тарифын дагуу төлбөртэйгөөр хийж гүйцэтгэнэ. Тарифт үйлчилгээний төлбөрийг уурын ДЭХ-ний төлбөртэй хамт төлнө.

Тав. Эрчим хүчний хангамж, хэрэглээг түдгэлзүүлэх

- 5.1. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан дараах тохиолдолд хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээний зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

Үүнд:

- 5.1.1. Эрчим хүч хэрэглэсний төлбөрөө төлөөгүй,
 - 5.1.2. Эрчим хүчний тооцооны тоолуур, хэмжүүр тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан,
 - 5.1.3. Хэрэглэгч нь хангагчийн зөвшөөрөлгүйгээр дулааны холболтын техникийн нөхцөл болон, гэрээнд заагдаагүй хэлбэрээр дулааны эрчим хүч хэрэглэсэн
 - 5.1.4. Хангагчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн хэрэглээний хүрээнээс өөр хэрэглэгчийг эрчим хүчээр хангасан.
 - 5.1.5. Хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн байранд нэвтэрч үзлэг, шалгалт, тооцоо хийх боломж олгоогүй.
 - 5.1.6. Байгалийн гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн, түлшний хомсдол бий болсон, эрчим хүчний хангамжид осол, саатал гарсан хүний амь нас эд хөрөнгөнд аюул учрах, гал түймэр гарах нөхцөл үүссэн.
- 5.2. Эрчим хүчний хяналтын улсын байцаагч энэ гэрээний 5.1-д зааснаас гадна дараах тохиолдолд хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Үүнд:
 - 5.2.1. Хэрэглэгчийн эрчим хүчний тоног төхөөрөмж, шугам сүлжээ нь ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага хангахгүй болсон.
 - 5.2.2. Эрчим хүч хэрэглэх техникийн нөхцөл зөрчсөн.
 - 5.2.3. Эрчим хүчний улсын хяналтын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтан нь хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх болсон талаар хэрэглэгчид 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэл өгөх ба түдгэлзүүлэх болсон үндэслэлээ тодорхой зааж, тоног төхөөрөмж, тоолуур, хэмжүүр, бусад шаардлагатай хэрэгслийг битүүмжилнэ.
 - 5.2.4. Эрчим хүчний улсын хяналтын байцаагч, хангагчийн эрх бүхий ажилтан нь энэ гэрээний 5.1.6-д заасан нөхцөл үүссэн үед хэрэглэгчийн эрчим хүчний хэрэглээг урьдчилан мэдэгдэхгүйгээр түдгэлзүүлж болно.
 - 5.2.5. Хэрэглэгч нь эрчим хүчний хэрэглээгээ түдгэлзүүлсэн зөрчлөө арилгасан тухайгаа эрчим хүчний улсын байцаагч болон хангагчийн эрх бүхий ажилтанд шалгуулахаас өмнө битүүмжилсэн тоног төхөөрөмж, хэрэгслийг ашиглахыг хориглоно.
 - 5.3. Хэрэглэгчийн хэрэглээг түдгэлзүүлэх хангагчийн эрх бүхий ажилтан нь түдгэлзүүлэх тухай шалтгааныг 48-аас доошгүй цагийн өмнө мэдэгдэх бөгөөд шууд түдгэлзүүлэх эрхгүй.

Зургаа. Шугам сүлжээний хамгаалалтын зурвас

6.1. Шугам сүлжээ нь аюулгүй байдлыг хангах хамгаалалтын зурвастай байна. Уг зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барихыг хориглоно.

6.2. Хамгаалалтын зурвасыг дүүргийн засаг дарга тогтоох ба уг зурваст шугам сүлжээнд гэмтэл учруулахаар буюу үзлэг үйлчилгээнд саад болохоор ургасан ба тарьсан мод буцыг өмчлөгч огтлох, шилжүүлэн суулгах үүрэгтэй.

6.3. Хангагчийн эрх бүхий ажилтан шугам сүлжээнд үзлэг үйлчилгээ хийх, хяналт хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын дагуу бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газар, барилга байгууламжид нэвтрэн орох, дайран өнгөрөх, эзэмшигч нь үүргээ биелүүлээгүй бол мод буцыг шилжүүлэн суулгуулах, боломжгүй бол огтлуулах эрхтэй.

6.4. Гэрээг үйлчлэх хугацаанд байгалийн гамшиг /аянга, гал түймэр, усны үер, хүчтэй салхи, мөстөлт гэх мэт/ дайн байлдаан, хүний амь нас, эд хөрөнгөнд аюул учрах нөхцөл үүссэн, ажил хаялт зарласан зэрэг давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг гэрээнд оролцогч талууд хариуцахгүй.

6.5. Талууд цаг агаарын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан гарсан аваарийг богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг авч ажиллах бөгөөд эрчим хүчний хангамжийг сэргээхэд шаардагдах хугацаа, залгалт хийж эхлэх цаг хугацааг харилцан шуурхай мэдээлж ажиллана.

Долоо. Хяналт, хариуцлага, маргааныг шийдвэрлэх

7.1. Хяналт:

7.1.1. Энэхүү гэрээнд заасан үйл ажиллагаа, гэрээний нөхцөл шаардлагын хэрэгжилтийг хянах зорилгоор хангагч байгууллагын эрх бүхий ажилтан дараах чиглэлээр мэргэжлийн хяналт тавина.

- Хэрэглэгчдийн тоног төхөөрөмж нь засвар, ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж байгаа байдал, түүний хэрэгжүүлэлтэд хяналт тавих
- Эрчим хүчийг зүй зохистой, хэмнэлттэй хэрэглэхэд болон шугам сүлжээг хамгаалах шаардлагыг мөрдүүлэхэд хяналт тавих.

7.1.2. Хангагч байгууллага нь өөрийн санаачилгаар болон бусад этгээдээс гаргасан гомдол хүсэлтийн дагуу гэрээнд заасан үйл ажиллагааг хянаж, шалгаж болно.

7.1.3. Хэрэглэгч гэрээний нөхцөл шаардлагыг зөрчсөн эсвэл биелүүлээгүй бол уг зөрчлийн талаар мэдсэнээс хойш 24 цагийн дотор хангагч, хэрэглэгчид утсаар мэдэгдэнэ.

7.1.4. Эрчим хүчний чанар стандарт, төлбөр тооцоотой холбоотой гомдлоо хэрэглэгч нь 48 цагийн дотор хангагчид бичгээр мэдэгдэнэ.

7.1.5. Хангагч нь энэ гэрээний 7.1-д заасан гомдлыг хүлээн авснаас хойш уг асуудлыг 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

7.1.6. Хэрэглэгч нь гэрээний зөрчил, параметрийн хэлбэлзлийн тухай 343097 дугаарын утсаар станцын ээлжийн инженерт болон 70111300 дугаарын утсаар станцын уурын хэсэгт мэдэгдэнэ.

7.2. Маргааныг шийдвэрлэх:

7.2.1. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан маргааныг хөөн хэлэлцэх хугацаа нь төлбөр тооцоо бодогдож гарснаас буюу техник технологитой холбоотой маргаан үүссэнээс хойш 48 цагийн дотор байх бөгөөд хэрэглэгч хангагчид албан ёсоор мэдэгдэж хангагч 7 хоногийн дотор хэрэглэгчтэй хамтран шийдвэрлэж тооцооны үнийн зөрүүг актаар тогтоож дараа сарын тооцоонд залруулан тусгана.

7.2.2. Уурын дулааны эрчим хүч тасалдсанаас болон чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс үүссэн маргаан (хохирол)-ыг шийдвэрлэхдээ хангагч, хэрэглэгчийн эрх бүхий албан тушаалтнууд (комисс) 24 цагийн дотор хамтран хохирлын хэмжээг тогтоож акт үйлдэн баталгаажуулсан байна. Уг актад хохирлыг барагдуулах хувь хэмжээг зааж өгөх ба түүнийг үндэслэн асуудлыг шийдвэрлэнэ.

7.2.3. Хангагч, хэрэглэгч хоёр нэг шийдвэрт хүрч чадахгүй бол дараагийн шатны байгууллагад хандан уг маргааныг шийдвэрлүүлнэ.

7.2.4. Эрчим хүчний хангамж, төлбөр тооцоо, хэмжих хэрэгсэл, бусад асуудлаар хэрэглэгчээс ирүүлсэн санал гомдлыг журмын дагуу шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

7.2.5. Гэрээтэй холбогдож үүссэн маргаантай асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл тухайн байгууллагын маргаантай асуудал ямар байгууллагын эрх хэмжээнд хамаарахыг харгалзан Эрчим хүчний зохицуулах хороо болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

7.2.6. Хэмжих хэрэгсэл, тоолуурын ажиллагаатай холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ шаардлагатай бол Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвийн улсын байцаагчаар дүгнэлт гаргуулсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

7.3. Хохирлыг нөхөн төлөх:

7.3.1. Энэ гэрээний 5.1-д зааснаас бусад зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулах үед хангагч нь хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр эрчим хүчийг тасалж хохирол учруулсан бол хохирлыг нөхөн төлнө. Хохирлын төлбөр тооцоог энэ гэрээний 7.2.2-т заасан актыг үндэслэн хийнэ.

7.3.2. Системийн болон бусад гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас болж, хэрэглэгчид хохирол учирсан бол хангагч хохирлыг хариуцахгүй.

7.3.3. Энэ гэрээний 5.1-р заалтад заасан үйл ажиллагааг явуулахдаа урьдчилан мэдэгдсэн байхад хэрэглэгч өөрийн буруугаас хохирол хүлээсэн бол эрчим хүчээр хангагч хариуцахгүй.

7.3.4. Хангагч, хэрэглэгчийн хооронд эрчим хүчний хангамж, хэрэглээтэй холбогдож гарсан хохирлыг талууд хамтран акт тогтоож баталгаажуулах бөгөөд актыг үндэслэн буруутай тал нь 1 сарын дотор хохирлыг нөхөн төлнө.

7.4. Хариуцлага:

7.4.1. Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомж дүрмийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруутай этгээдэд эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэсэн эсэхийг үл харгалзан учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

7.4.2. Гэрээний үүргээ зөрчсөн буюу биелүүлээгүй бол Эрчим хүчний тухай хууль бусад холбогдох хууль, дүрэм, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Найм. Бусад нөхцөл

8.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба талууд гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгэснээр гэрээний үйлчлэл дуусгавар болно.

8.2. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний нөхцлийг өөрчлөх шаардлага гарвал талуудын харилцан зөвшилцөж, албан ёсоор бичгэн хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж гарын үсэг зурж, тамга дарснаар баталгаажсанд тооцно. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.

8.3. Талууд энэхүү гэрээнд тусгагдаагүй асуудлыг мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.4. Харилцагч талууд гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлсэн компани, хувь хүмүүсийг харилцан шагнаж урамшуулж болно.

8.5. Гэрээг Монгол хэл дээр 2% үйлдэж, талууд тус бүр 1%-ийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй байна.

8.6. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээний үүргийн биелэлтийг хамтран дүгнэж, 2% акт үйлдэнэ.

Ес. Мэдээлэл, параметрууд

9.1. Хангагчийн Уурын параметр: /Станцын коллекторт/

- 4-р сарын 15-наас 10-р сарын 15-н хүртэл P=8-11 ата, T=290°C
- 10-р сарын 15-наас 4-р сарын 15-н хүртэл P=6 ата, T=290 °c байна.

9.2. Уурын дулааны эрчим хүчний тооцоо, төлбөр хийх хугацаа

д/д	Агуулга	Хуанлийн өдрүүд
1	Сар бүрийн тоолуурын заалт авах өдөр	1 – 5
2	Төлбөрийн нэхэмжлэх хүрсэн байх өдөр	5 – 6
3	Тухайн сарын уурын төлбөрөө төлсөн байх сүүлийн өдөр	20
4	Алданги тооцож эхлэх өдөр	21
5	Эрчим хүчээр хязгаарлах	25

9.3. Хангагч талын мэдээлэл

Нэр: Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК
 Хаяг: 17070, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө
 Вэб сайт: www.tes3.energy.mn
 И мэйл хаяг: thermalpowerplant3@gmail.com
 Утасны дугаар: Төлбөр тооцоотой холбоотой асуудлаар (ажлын цагаар) - 70111320
 Тоолуур хэмжих хэрэгсэл, эрчим хүчний хангамжтай холбоотой асуудлаар - 70111300 (уурын хэсэг), 343097 (жижүүрийн инженер)

9.4. Банкны харилцах данс

№	Банкны нэр	Дансны дугаар
1	Худалдаа хөгжлийн банк	406001038
		2603001370
2	Төрийн банк	105400001612
3	Голомт банк	1102037031
4	Хаан банк	5020501745
5	Хас банк	5002864888
6	Капитрон банк	3004011490

9.5. Хэрэглэгч талын мэдээлэл

Байгууллагын мэдээлэл:

Агуулга	Үзүүлэлт
Хэрэглэгчийн нэр	"Би Ти Өү" ХХК
Татвар төлөгчийн дугаар	5084091
Улсын бүртгэлийн дугаар	9011077094
Хэрэглэгчийн хаяг байршил	УБ хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн баруун бүс
Үйл ажиллагааны чиглэл	Хатуу болон хайрган хучилттай зам гүүр, замын байгууламж барих, засварлах
Холбогдох хүмүүсийн утасны дугаар	Оюунцэцэг – 99060000 Батболд – 99115898 Мөнхзул - 94115020
Электрон шуудангийн хаяг	ecoasphalt99@gmail.com


Техникийн нөхцлийн мэдээлэл:

Агуулга	Үзүүлэлт
Техникийн нөхцөл олгосон огноо	2019.08.29
Уурын хэрэглээ /Технологийн хэрэгцээнд/	1.0 тн/цаг
Уурын шугамын чиглэл	Алтан дорнод
Холболтын цэг дээрх уурын параметр	P = 5 кгс/см ² T = 150°C
Дулааны тооцоот дээд ачаалал	0.657 Гкал/цаг
Холболтын цэг	Үйлдвэрийн уурын Алтан дорнод чиглэлийн Ø159 мм-ийн салбар шугамаас
Тоолуур хэмжих хэрэгслийн үйлдвэрийн дугаар	47118A69

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАНГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

 П.БОЛДБААТАР

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЛБАНЫ ДАРГА

 Л.БӨХБОЛД

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧИЙН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 О.ЭНХБАЯР

БОРЛУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА


 Ч.МӨНХБАТ

УУРЫН ХЭСГИЙН ДАРГА


 Б.ЗОЛЗАЯА

ХЯНАСАН:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Ц.ОЮУН-ЭРДЭНЭ

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

 Г.БАТНЯМ

ХЭРЭГЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НЯГТЛАН БОДОГЧ

 Б.МӨНХЗУЛ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Барилга, хот байгуулалтын сайдын
2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн
А/719/189 дүгээр тушаалын хавсралт



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 23/01

.....**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**.....-ын гаргасан
/ Дүгнэлт гаргасан байгууллага /

20...²² оны ...¹² дугаар сарын ...¹² ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах **ХУД 22/130**

дүгнэлтийг үндэслэн**Улаанбаатар хот**..... аймаг/нийслэл**Хан-Уул**.....

сум/дүүргийн**3 дугаар хороо ТЭЦ3-ын баруун талд**..... байршилтай
/ хаяг /

.....**унд, ахуйн**.....
/ үйл ажиллагааны чиглэл /

чиглэлээр хаягдал ус гаргаж байгаа**"Эко асфальт" ХХК**.....-д
/ хүн, хуулийн этгээдийн нэр /

.....**Улаанбаатар хот** аймаг/нийслэл,**Хан-Уул**..... сум/дүүргийн
47°53'28.35"

.....**3-р хороо 106°51'29.39" солбилцолд**..... байршилтай хаягдал

ус зайлуулах цэг буюу хүрээлэн буй орчинд болон төвлөрсөн бохир усны
шугамд жилд**187,2**..... мян.м³ хаягдал усыг "Хүрээлэн байгаа

орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015",

"Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд

нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015" стандартаар

тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг

/ аль нь болохыг доогуур нь зурах /

нэг жилийн хугацаагаар олгож, ус бохирдуулсны төлбөрийн гэрээ болон

дүгнэлтийг зөрчөөгүй тохиолдолд зөвшөөрлийг жил бүр сунгагдсанд тооцно.

Хаягдал усны хэмжээ болон хаягдал ус зайлуулах цэг, төвлөрсөн бохир усны

шугамын байршил өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр шинээр зөвшөөрөл олгоно.

Зөвшөөрлийн бичиг олгосон:

ХУД-ийн ЗДТГ

/ Зөвшөөрөл олгосон байгууллага /

Тамга

ТНААХ-н дарга

Г.Туяацэцэг

/ Гарын үсгийн тайлал /

20 ²³ оны ⁰⁵ -р сарын ¹⁵ -ны өдөр

СУНГАЛТ

Сунгалт хийсэн шийдвэр	Огноо	Гарын үсэг / тамга



**НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/НБ

Улаанбаатар хот

Г Хаягдал ус хаях зөвшөөрөл олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 24 дүгээр зүйлийн 24.2, 24.5, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг; Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А/719/189 дүгээр хамтарсан тушаал, Туул голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ХУД 22/130 дугаартай Хаягдал усны дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт асфальт бетон хольцын үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Эко асфальт” ХХК-ийн хэрэглээнээс гарсан бохир усыг хаягдал усны дүгнэлтийн дагуу хаяхыг зөвшөөрсүгэй.

2. “Эко асфальт” ХХК-д хаягдал ус хаях зөвшөөрлийн бичиг олгож, хяналт тавьж ажиллахыг Тохижилт, ногоон байгууламж, хог хаягдлын удирдлагын хэлтэс (Г.Туяацэцэг)-т даалгасугай.

3. Усны тухай хуульд заасан үүргээ биелүүлж, усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай холбогдох мэдээ, тайлан, хаягдал ус хаях зөвшөөрөл, ус бохирдуулсны төлбөр төлсөн баримтыг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг “Эко асфальт” ХХК (Д.Батболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

170/200133



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ ГЭРЭЭ

Дугаар 10/18

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Туул голын сав газрын захиргааны гаргасан 2022 оны 12-р сарын 12-ны өдрийн ХУД 22/130 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төхижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ганболд овогтой Туяацэцэг, нөгөө талаас ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, ТЭЦ 3-ын баруун талд байрлах 9011571011 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 6001769 тоот регистрийн дугаартай “Эко асфальт” ХХК-ийг төлөөлж захирал Д.Батболд нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 /нэг/ жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татгуурын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 6561:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын нормтив шаардлагад нийцүүлсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөр, стандартын нормтив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны нөхөн төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харьяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.3.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.3.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.3.4. Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.3.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.3.5. Ус бохирдуулсны төлбөр төлсөн тайлан.

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно;

3.3. Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоолгох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны эзлэхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх зэрэг эрсдэлээс хамгаалагдсан эд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрыг төлөөлж:

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Г.Туяацэцэг

Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Хог хаягдлын менежмент, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн

Б.Эрдэнэзул

Хаяг: ХУД-ийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байр, 4 давхар, 403 тоот

“Эко асфальт” ХХК-ийг төлөөлж:

Захирал



Д.БАТБОЛД

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, ТЭЦ 3

Утас: 99115898, 99060000

ГЭРЭЭ ХЯНАСАН:

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.БАЙГАЛЬ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023/A-320
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Эко Асфальт” ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2023.10.20
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот ХУД 3-р хороо
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 5002:2000, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2023.10.21
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м ³			
1	Үйлдвэр орчим	X/20	10:15	0.012	0.025	0.700	70	
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016, Хүлцэх агууламж (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60	

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:


Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2023 / Б-186
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “Эко Асфальт” ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Цэвээн, 99605041
Сорьцын тоо, төрөл : 1, Бохир ус
Сорьц авсан огноо : 2023.10.20
Сорьцын тодорхойлолт : Бохир усны сорьц
Шинжилгээний аргын стандарт : **MNS ISO 10523:2001, MNS 6836 :2020**
MNS ISO 6060:2001, MNS ISO 5815-1:2015
MNS ISO 7150-1:2006, MNS 6779:2019,
MNS 6834:2020, MNS ISO 6878:2001
Шинжилсэн огноо : 2023.10.21-2023.10.30
Хуудасны тоо : 1 /1
Үр дүн : 1

Сорьцын авсан цэг	pH	Ж/б мг/л	XXX мг/л	БХХ ₅ мг/л	NH ₄ мг/л	NO ₂ мг/л	NO ₃ мг/л	N _{нийт} мг/л	P _{эрд} мг/л
ХУД, 3-р хороо Замын асфальт үйлдвэр Үйлдвэрийн бохир	6.76	132	261	189	4.20	0.039	2.30	3.79	0.140
MNS 6561:2015	6-9	400	800	400	15	-	-	30	5

Тайлбар: Ж/б- Жинлэгдэгч бодис, XXX- Химийн Хэрэгцээт Хүчилтөрөгч, БХХ₅- Биохимийн Хэрэгцээт Хүчилтөрөгч

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Шалгасан инженер:

Хянаж баталгаажуулсан инженер:



Ц.Мийдүв

С.Отгонжаргал

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2023 оны 04 сарын 05-ны өдөр

№ 23/56

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, 6278558 тоот регистрийн дугаартай Хан-Уул дүүргийн ЭКО ХОТЫН ТЭЭВЭР ААТУГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 6001769 тоот регистрийн дугаартай, Хан - Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах ЗАМЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ЭКО АСФАЛЬТ ХХК /цаашид Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 “Хог хаягдлын тухай” хуулийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45 дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.
- 1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29 тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.
- 1.6 Хороо нь гэрээний дагуу хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавьж Захиалагч, Гүйцэтгэгч хоорондын уялдааг хангана.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хүргэх, ачилтын мэдээг тухай бүр хороонд мэдээлж ажиллах үүрэгтэй.
- 2.2 Гүйцэтгэгчийн тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар зохион байгуулалт хийн хогийг ачуулах арга хэмжээг авна.

- 2.3 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ААНБ-аас гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн нэмэлтээр барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлыг төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч, ачигч нь зохих сургалтад хамрагдаж аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллана.
- 2.6 Хорооноос өгсөн чиг үүргийн дагуу Гүйцэтгэгч нь тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй ААНБ-ын хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал "Хог хаягдлын тухай" хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 ААН, байгууллага нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савтай байх.
- 3.3 Тээвэрлүүлэх хог хаягдлыг зөвхөн тогтоосон хог ачилтын цэг буюу бункерт хийх, ачилт хийхэд саадгүй байхаар орц, гарцыг төлөвлөсөн байна.
- 3.4 ААН, байгууллага нь Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4.12, 10 дугаар зүйлийн 2.10 дах заалтуудын дагуу дүүрэг, хорооноос тогтоосон, "**хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар**"-ын хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнээс гарах хог хаягдлыг тээвэрлүүлнэ.
- 3.5 Захиалагч тал нь гэрээний 3.2, 3.3-т заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.
- 3.6 Хог хаягдлын төлбөрийг **сар бүрийн 25-нд Хан-Уул дүүргийн Татварын Хэлтэст** болон **itax.mta.mn** сайтаас төлбөрийн даалгавар үүсгэн төлнө. 20-р хороо, Эко хотын тээвэр ААТҮГ-ыг сонгоно.
- 3.7 Хогийн сав, бункерийн орчимд машин, болон бусад зүйл байрлуулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.
- 3.8 Захиалга буюу хог хаягдал ачих, тээвэрлэх дуудлагыг **2-3** хоногийн өмнө хороо болон гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 3.9 Хог хаягдал тээвэрлүүлсэний төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.
- 3.10 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.
- 3.11 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.12 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.
- 3.13 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.
- 3.14 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

4.1 Гэрээт хугацаанд сард **РЕЙС** өдөр удаа иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

4.2 Хог тээвэрлэлтийн төлбөр нь Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард төгрөг, улиралд төгрөг, жилд төгрөг байна. **1тн хогны үнэ 75000 төгрөг**

4.3 Захиалагч нь **itax.mta.mn** цахим хаягаар орж төлбөрийн даалгавар үүсгэн нэхэмжлэхийн дугаараар хог хаягдлын хураамжаа хугацаанд нь бүрэн төлнө. 20-р хороо, Эко хотын тээвэр ААТҮГ-ыг сонгоно.

4.4 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актыг үндэслэн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.

4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.

4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.6-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам **0,5%-ийн алданги** төлнө.

Тав. Хамтран хүлээх хариуцлага

5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.

5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.3 Нийслэл, дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь **1** өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.

6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

Долоо. Бусад

7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.3 Тус гэрээнд дүүрэг, хорооноос тогтоосон "Хариуцах орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар"-ын зураглалыг хавсаргасан тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ.

Найм. Нэмэлт өөрчлөлт

20... оны сарын-ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Ажлын тогтмол цэг дахь **рейс** ачилт хийх.

Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20..... оны сарын өдрөөс 20..... оны сарын өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: _____

Гэрээ сунгасан: _____

Тайлбар: _____

9.1.2 Энэхүү гэрээг 20... оны ... сарын ... өдрөөс 20.. оны ... сарын ... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: _____

Гэрээ сунгасан: _____

Тайлбар: _____


Арав. Гэрээ байгуулсан талууд

Гүйцэтгэгч тал:

3-р хорооны

Зохион байгуулагч

албан тушаалтай


Д.ЗОЛЖАРГАЛ


Утас: 77196503 92023883

Хаяг: 3-р хороо, Алтаргана хотхон

Эко Хотын тээвэр ААТҮГ

Хорооны хог хаягдал хариуцсан

ахлах мэргэжилтэн


Ш.ОЮУНЖАРГАЛ


Утас: 88281908

Захиалагч тал:

ЭКО АСФАЛЬТ ХХК

албан тушаалтай

няглан бодогч

И.Г.МӨНХЗУЛ/ 


Утас: 94115020

Хаяг: ХУД 3 хороо, АЖИЛЧДЫН ГУДАМЖ, ТЭЦЗ
БАРУУН ТАЛД

2023 оны 04 дугаар сар 05 өдрийн 23/56 дүгээр
" Хог хаягдал цуглуулах , тээвэрлэх гэрээний хавсралт

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНД БАЙРЛАХ ЭКО АСФАЛТ ХХК -ЫН ТОХИЖИЛТ,
ЦЭВЭРЛЭГЭЭГ ХАРИУЦАХ ОРЧНЫ 50 МЕТР ХҮРТЭЛХ НИЙТИЙН ЭЗЭШЛИЙН ЗАМ,
ТАЛБAYН ЗУРАГЛАЛ

Байгууллагын нэр:	ЭКО АСФАЛТ ХХК
Захирлын овог нэр, утасны дугаар	Б.БАТБОЛД
Хаяг,байршил	АЖИЛЧНЫ ГУДАМЖ
